



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар A/151

Улаанбаатар хот

┌ Тэмцээний зардал гаргах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, 20 дүгээр зүйлийн 20.1.2 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өсвөрийн шатарчдын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн 2023 оны 10 дугаар сарын 14-нөөс 27-ны өдрүүдэд Египэт улсын Шарм Эль Шэйх хотод болох тэмцээний 12 насны ангилалд Наранболдын Содгэрэлтийг дасгалжуулагчтай хамт оролцуулсугай.

2.Тэмцээний тээврийн зардалд 500,000 (Таван зуун мянга)-н төгрөгийг спортын тэмцээн уралдааны зардлаас гаргахыг Нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Спортын хэлтсийн дарга (Ю.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНСҮРЭН